АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ДУНДГОВЬ АЙМАГТ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР ХИЙСЭН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

Илтгэгч: Аймгийн ЗДТГ-ын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
А.Нарантуяа


АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА






- **Газар нутгийн хэмжээ** - 74.7
- **Аймгийн төв** - Мандалговь
- **Улаанбаатар хотоос** - 265 км
- **Засаг захиргааны нэгж** - 15 сум, 66 баг
- **Хил хязгаар** - Төв, Говьсүмбэр, Өмнөговь, Дорноговь, Өвөрхангай аймгуудтай хиллэдэг.
- **Хүн ам /2018 он/** - 46820
  - Эрэгтэй - 23569
  - Эмэгтэй - 23251
- **Өрхийн тоо /2018 он/** - 14863
  - Өрх толгойлсон эмэгтэй -1913

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН САЛБАР ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА



ЗАСАГ ДАРГА



Салбар хорооны бүрэлдэхүүн

Дарга

Нарийн бичгийн дарга

Гишүүд:

Аймгийн Засаг дарга

Аймгийн ЗДТГ-ын Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн дарга

Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Боловсрол, соёл, урлагийн газрын дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Статистикийн хэлтсийн дарга

Хүний эрхийн үндэсний комиссын Дундговь аймаг дахь

Аймгийн эрэгтэй-хүүхэн хорооны дарга

Аймгийн Засаг даргын 2016 оны 11 сарын 16-ны өдрийн А/414 тоот захирамжаар төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон 15 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа.

ХҮЙСИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫН СУДАЛГАА

15 сум, 111 төрийн байгууллагад

Нийт төрийн албан хаагчдын тоо

- эрэгтэй
- эмэгтэй

Гүйцэтгэх албан тушаалтан

- эрэгтэй
- эмэгтэй

Удирдах албан тушаалтан

Улс төрийн

- эрэгтэй
- эмэгтэй

Захиргааны

- эрэгтэй
- эмэгтэй

Үйлчилгээний

- эрэгтэй
- эмэгтэй

Төрийн тусгай

- эрэгтэй
- эмэгтэй

ҮЙЛ АЖИЛЛАГАА .....



Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор хүүхдийн язгуур эрх ашгийг хамгаалах, хүүхдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хүчирхийлэлд өртүүлэхгүй байх зорилгоор “ХҮҮХДИЙН ДУУ ХООЛОЙ БА ҮР НӨЛӨӨ” чуулганыг зохион байгуулж, хүүхдүүдээ сонсох өдрийг сар бүрийн 03-05-ны аль нэг ажлын өдөрт зохион байгуулж байхаар шийдвэрлэлээ.

Олон улсын гэр бүлийн баярын өдрийг тохиолдуулан аймгийн "Тэнгэрлэг гэр бүл"-ийг шалгаруулдаг ёслолын арга хэмжээ 7 дахь жилдээ зохион байгууллаа.

Энэ жил “Оюунлаг гэр бүл”, “Бүтээлч гэр бүл”, “Өнөр гэр бүл”, “Спортлог гэр бүл”, “Авъяаслаг гэр бүл” гэсэн номинациудаар шилдгүүдээ шалгаруулж алдаршууллаа.







"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийг сурталчилж, гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, санаа бодол, дуу хоолойг олон нийтэд хүргэх, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хамгаалахад үүрэг хүлээгчдийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор "Хайртай бүхнээ хамгаалцгаая" уриан дор тайван жагсаалыг ГБХЗХГазар, Скаутын холбоотой хамтран зохион байгууллаа.



- Тодорхой 1 өдрийг эцэг эхтэй хамтран ажиллах өдөр болгож аавуудыг 7 хоногоор ээлжлэн сургуулийн орчинд аавуудын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Аав ээжүүдийн тэгш оролцоог хангах үүднээс аймгийн хэмжээний 21 цэцэрлэгийн хэмжээнд "Аавуудын нэг өдөр" арга хэмжээг зохион байгууллаа.

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

- Жендэрийн салбар хорооны гишүүд болон агентлагын зарим удирдлагууд, төрийн байгууллагуудын хүний нөөц хариуцсан мэргэжилтнүүд зэрэг давхардсан тоогоор 36 хүнийг салбар, орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн чиглэлээр бүсийн сургалтанд 2 удаа хамруулсан.
- Сумдын ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, сумдын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтнүүд, байгууллагуудын хяналт шинжилгээ, үнэлгээ болон хүний нөөц хариуцсан мэргэжилтнүүд зэрэг 9 байгууллагын 150-аад хүнд жендэр, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт сэдвээр сургалт зохион байгууллаа.
- Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай байгуулдаг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар заалт тусгаж оруулдаг.

- Мерит төсөлтэй хамтран Жендэрийн сургагч багшаар 3 төрийн албан хаагчийн 5 хоногийн сургалтанд хамруулж бэлтгэлээ. Мөн төслийн хүрээнд жендэрийн салбар хорооны гишүүд, байгууллагын хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэнүүд зэрэг 35 хүнд “Жендэрийн тэгш байдлыг хангах нь” сэдэвт сургалтыг Канадын олон улсын зөвлөх багшаар заалгаж сургалтанд хамруулаа.
- Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид болон холбогдох төрийн албан хаагчид 150 хүн оролцсон уул уурхайн зөвлөгөөнд “Уул уурхайн салбар ба жендэр” сэдвээр сургалт мэдээлэл хийж жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүллээ.

- “Иргэний нийгмийн байгууллагын сүлжээ” ТББ-аар Дундговь аймгийн Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээг аймгийн Засаг даргын 1.5 сая төгрөгний дэмжлэгтэй хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүд, ИТХ-ын тэргүүлэгч нарт танилцуулсан.
- Дундговь аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан 2019 оны 6 сард батлан хэрэгжүүлж байна. Энэ дагуу Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооны хийх ажлын төлөвлөгөө болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж жилд 2-оос доошгүй удаа хуралдаж байна.

- “Хүчирхийллийн эсрэг хамтдаа” аяныг зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн тухай, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн 10 гол өөрчлөлт” сэдвүүдээр 245 иргэнд мэдээлэл өгч, сургалт зохион байгууллаа.

- Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зааltыг төрийн байгууллагууд хөдөлмөрийн дотоод журамд тусгах чиглэлийг өгч, хэрэгжилтэд хяналт тавьж байгууллагуудаас мэдээлэл авч ажиллалаа.

- “Жаргалтай гэр бүл” аянд 40 өрхийг хамруулж, аяны хугацаанд гэр бүлийн боловсрол олгох сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө тусламж үзүүлэх, бага насны хүүхдийг цэцэрлэгт хамруулах, секц дугуйланд хамруулах зэрэг үйлчилгээ үзүүллээ.
- “Гэр бүлийн болзоо” тусгай арга хэмжээг Цагдаагийн газар, Хулд сумын сумын залуу гэр бүл нийт 270 гэр бүлийг хамруууллаа. Хамрагдсан гэр бүлүүд гэр бүлийн харилцааны эерэг хандлага төлөвшил, үнэ цэнэ, хүүхдээ зөв хүн болгон хүмүүжүүлэх хүүхэд хүмүүжлийн эерэг аргад суралцаж, үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй “ЗӨВ ТУСГАЛ” хөдөлгөөнд нэгдлээ.





- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг Хүний эрхийн комиссын орон нутаг дахь мэргэжилтэн, ГБХЗГ-тай хамтран “Ойлгоё хүндэлье-Гэр бүлийнхээ төлөө” уриан дор зохион байгуулж, аяны хүрээнд “Цагаан туузтаны хөдөлгөөн”-д төрийн байгууллагууд нэгдэж, ажилтан албан хаагчдад жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдээ мэдээллийг хүргэлээ.





- Хүчирхийллийн хохирогчдыг аливаа гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэдэнд нийгэм сэтгэл зүй, хууль эрх зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх зорилготой “Түр хамгаалах байр”-ны үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулсан. Энэ хүрээнд өмнөх тог, цахилгаан, халаалтын өрийн асуудал зарим засварын ажлын зардлыг аймгийн Засаг даргын зүгээс шийдвэрлэн өгч ГБХЗХГ үйл ажиллагааг нь хариуцан шаардлагатай тоног төхөөрөмж болон орчин нөхцлийг сайжруулахад анхааран засварын ажлыг нь хийж өглөө. 2017 оноос хойш тус төвийн урсгал зардлыг орон нутаг шийдвэрлэж байна.


Thank You!